



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/334

Булган сум

Гар зургийн уралдааны зардалд
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хиймэл оюун ухааны хэрэглээ ба цахимжилт” сэдэвт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд зохион байгуулсан гар зургийн уралдааны шагналын зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шагналын зардалд шаардагдах 795,000 (долоон зуун ерэн таван мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 20-ны/ний өдрийн
А/334 дугаар захирамжийн хавсралт

ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ХЭРЭГЛЭЭ БА ЦАХИМЖИЛТ УРИАН ДОР
ЗОХИОН БАЙГУУЛСАН ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ ШАГНАЛЫН ЗАРДАЛ

д/д	Шагналын нэр	Шагналын мөнгөн дүн	Өргөмжлөл	Мөнгөн дүн
1	2	3	4	5
1	Гар зургийн уралдаан	1-р байр – 300,000	25,000	325,000
		2-р байр – 200,000	25,000	225,000
		3-р байр – 100,000	25,000	125,000
		4-р байр оролцооны шагнал– 40.000	-	40,000
		5-р байр оролцооны шагнал – 40.000	-	40,000
		6-р байр оролцооны шагнал – 40.000	-	40,000
Нийт дүн				795,000